



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 3 дугаар сар

**Ерөнхий тойм:** Оны эхний 3 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 12.4%-иар буюу 221.5 сая ам.доллараар буурч 1558.0 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 11.0%-иар буюу 118.8 сая ам.доллараар, импорт 14.6%-иар буюу 102.7 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 359.9 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 16.1 сая ам.доллараар буурсан үзүүлэлт байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 3 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10 627	11 011	8 467	384	3.6%	(2 545)	-23.1%	1 983	1 779	1 558	(203)	-10.3%	(221)	-12.4%
Экспорт	4 269	5 775	4 669	1 506	35.3%	(1 105)	-19.1%	987	1 078	959	91	9.2%	(119)	-11.0%
Импорт	6 358	5 237	3 797	(1 121)	-17.6%	(1 439)	-27.5%	996	702	599	(294)	-29.5%	(103)	-14.6%
Тэнцэл	(2 089)	538	872	2 627	x16	334	62.2%	(9)	376	360	385	x43	(16)	-4.3%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлтүүдийн нэг юм. 2010 оноос хойш тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас ашигтай гарч эхэлсэн. Уг үзүүлэлт 2016 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр 365.7 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 22.6 сая ам.доллараар буурсан байна.

Дүрслэл 1. Валютын төлбөртэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62.0% буюу 966.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 10.9% буюу 169.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 12.4%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 28.2%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.3 сар	2016.2 сар	2016.3 сар	Жил Δ	Сар Δ
<b>Экспорт</b>	<b>0.84</b>	<b>0.73</b>	<b>0.68</b>	<b>-19%</b>	<b>-7%</b>
Зэсийн баяжмал	0.43	0.36	0.33	-24%	-8%
Чулуун нүүрс	0.54	0.42	0.38	-31%	-11%
Ямааны угаасан ноолуур	0.37	0.34	0.32	-13%	-4%
<b>Импорт</b>	<b>0.57</b>	<b>0.59</b>	<b>0.54</b>	<b>-5%</b>	<b>-9%</b>
Хэрэглээний бараа	0.75	0.79	0.76	2%	-3%
Хөрөнгө оруулалтын бараа	0.47	0.57	0.48	1%	-16%
Нефтийн бүтээгдэхүүн	0.56	0.42	0.40	-29%	-5%
<b>Худалдааны нөхцөл</b>	<b>1.48</b>	<b>1.23</b>	<b>1.26</b>	<b>-15%</b>	<b>3%</b>

\* Индексийн өөрчлөлтөд голлохувь нэмэр оруулсан бараагаар задлав.

**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 14.9%-иар буурч, өмнөх сараас 2.8%-иар өсч 1.263-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалтын бараа болон нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ буурсан нь ийнхүү худалдааны нөхцөл өмнөх сараас сайжрахад нөлөөлжээ.

Экспортын гадаад худалдаа 2016 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 11.0%-иар буюу 118.8 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 1%-иар өсөхөд нөлөөлсөн ч, уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 12%-иар буурахад нөлөөлжээ. Улмаар уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 3 нэгж хувиар өссөн байна.

**Хүснэгт 3. Экспортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мйн нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мйн нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мйн нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
<b>1. Уул уурхай</b>		<b>910</b>	<b>92%</b>	<b>968</b>	<b>90%</b>		<b>843</b>	<b>88%</b>		<b>58</b>	<b>6%</b>	<b>6%</b>	<b>(125)</b>	<b>-13%</b>	<b>-12%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	214	348	35%	309	512	48%	413	482	50%	165	47%	17%	(31)	-6%	-3%
1.2. Чулуун нүүрс	3 737	206	21%	3 245	141	13%	3 252	99	10%	(64)	-31%	-7%	(42)	-30%	-4%
1.3. Боловсруулаагүй нефть	1 517	149	15%	1 921	92	9%	2 221	73	8%	(57)	-38%	-6%	(19)	-20%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	913	82	8%	998	58	5%	988	29	3%	(24)	-29%	-2%	(29)	-50%	-3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	2 172	90	9%	2 456	98	9%	2 902	111	12%	8	9%	1%	13	14%	1%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	15	15	1%	28	35	3%	23	23	2%	20	140%	2%	(12)	-36%	-1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	56	12	1%	56	13	1%	53	12	1%	1	7%	0%	(1)	-9%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	7	1%	1	9	1%	2	6	1%	2	23%	0%	(3)	-30%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	2	0%	0	2	0%	0	2	0%	1	39%	0%	(1)	-28%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	-	0%	27	7	1%	17	6	1%	7		1%	(1)	-12%	0%
1.11. Бусад	10	0	0%	0	0	0%	19	1	0%	(0)	-99%	0%	1		0%
<b>2. Мал аж ахуй</b>		<b>32</b>	<b>3%</b>	<b>33</b>	<b>3%</b>		<b>35</b>	<b>4%</b>		<b>1</b>	<b>3%</b>	<b>0%</b>	<b>2</b>	<b>6%</b>	<b>0%</b>
2.1. Амьд мал, малын мах	0	1	0%	1	3	0%	1	3	0%	2	194%	0%	(0)	-16%	0%
2.2. Арьс, шир	139	17	2%	99	11	1%	61	12	1%	(5)	-31%	-1%	1	8%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	2	0%	0	3	0%	0	1	0%	0	12%	0%	(1)	-46%	0%
2.4. Ноолуур	2	9	1%	1	13	1%	1	14	1%	4	41%	0%	1	10%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	2	3	0%	2	3	0%	3	5	0%	0	6%	0%	1	41%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-45%	0%	0	127%	0%
<b>3. Газар тариалан</b>		<b>12</b>	<b>1%</b>	<b>17</b>	<b>2%</b>		<b>7</b>	<b>1%</b>		<b>5</b>	<b>41%</b>	<b>1%</b>	<b>(10)</b>	<b>-59%</b>	<b>-1%</b>
<b>4. Ажүйлдвэрлэл</b>		<b>32</b>	<b>3%</b>	<b>58</b>	<b>5%</b>		<b>73</b>	<b>8%</b>		<b>26</b>	<b>81%</b>	<b>3%</b>	<b>14</b>	<b>25%</b>	<b>1%</b>
4.1. Хүнс	0	1	0%	1	10	1%	2	12	1%	9	x11	1%	2	19%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	3	0%	0	3	0%	0	2	0%	0	11%	0%	(1)	-44%	0%
4.3. Бусад хууцас, гутал, эдлэл	0	1	0%	0	1	0%	0	3	0%	0	26%	0%	1	84%	0%
4.4. Уул уурхай	2	5	0%	6	19	2%	5	16	2%	14	x4	1%	(4)	-19%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	0	0%	0	0	0%	(1)	-69%	0%	(0)	-28%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	19	2%	0	23	2%	0	40	4%	4	18%	0%	17	73%	2%
4.7. Бусад	60	2	0%	65	1	0%	57	1	0%	(1)	-27%	0%	(0)	-17%	0%
<b>5. Бусад</b>		<b>0</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>0%</b>		<b>0</b>	<b>0%</b>		<b>0</b>	<b>67%</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-56%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>987</b>		<b>1 078</b>			<b>959</b>			<b>91</b>	<b>9%</b>		<b>(119)</b>	<b>-11%</b>	


% 2 - Нийт өсөлтөө оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

**Хүснэгт 4. Экспортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>139.5</b>	<b>-12%</b>	<b>(264.2)</b>	<b>212%</b>	<b>(124.7)</b>	<b>-13%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	120.6	-394%	(151.3)	494%	(30.6)	-6%
1.2. Чулуун нүүрс	0.2	-1%	(42.7)	101%	(42.4)	-30%
1.3. Боловсруулаагүй нефть	9.9	-53%	(28.5)	153%	(18.6)	-20%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(0.3)	1%	(28.9)	99%	(29.2)	-50%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	17.1	128%	(3.8)	-28%	13.3	14%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(5.3)	43%	(7.1)	57%	(12.5)	-36%
1.7. Жонш, лейцит, нефелинт	(0.9)	75%	(0.3)	25%	(1.2)	-9%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1.9	-73%	(4.6)	173%	(2.7)	-30%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	(0.5)	76%	(0.2)	24%	(0.7)	-28%
1.10. Мөнгө /тонн/	(3.9)	457%	3.1	-357%	(0.9)	-12%
1.11. Бусад	0.6	100%	(0.0)	0%	0.6	0%
<b>2. Мал аж ахуй</b>	<b>(5.8)</b>	<b>-304%</b>	<b>7.7</b>	<b>404%</b>	<b>1.9</b>	<b>6%</b>
2.2. Арьс, шир	(7.7)	-815%	8.7	915%	0.9	8%
2.4. Ноолуур	1.1	88%	0.1	12%	1.2	10%
<b>3. Газар тариалан</b>	<b>(13.8)</b>	<b>137%</b>	<b>3.8</b>	<b>-37%</b>	<b>(10.0)</b>	<b>-59%</b>
<b>4. Ажүйлдвэрлэл</b>	<b>(3.1)</b>	<b>-22%</b>	<b>17.6</b>	<b>122%</b>	<b>14.5</b>	<b>25%</b>
<b>5. Бусад</b>	<b>0.0</b>	<b>-4%</b>	<b>(0.4)</b>	<b>104%</b>	<b>(0.4)</b>	<b>-56%</b>
<b>Нийт дүн</b>	<b>116.8</b>		<b>(235.6)</b>		<b>(118.8)</b>	<b>-11%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



2016 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 116.8 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 235.6 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл уул уурхайн түүхий эдийн экспортын тоо хэмжээ өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж уг бүлгийн экспорт 12.9%-иар буюу 124.7 сая ам.доллараар буурчээ.

Мал аж ахуйн түүхий эдийн экспортын үнэ өссөнөөс шалтгаалан уг бүлгийн экспорт 1.9 сая ам.доллараар, рапсын экспортын бууралтаас шалтгаалж газар тариалангийн экспорт 10.0 сая ам.доллараар тус тус буурсан байна. Харин машин механик, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 24.8%-иар буюу 14.5 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны сарын дундаж үнэ 2016 оны 3 сард 1,244 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5%-иар, өмнөх сараас 4%-иар тус тус өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,954, 56 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 17%-иар, төмрийн хүдэр 4%-иар тус тус буурсан бол өнгөрсөн сартай харьцуулахад зэс 8%-иар, төмрийн хүдэр 19%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 3 сард 30 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39%-иар, өмнөх сараас 13%-иар тус тус буурсан байна.

Импортын гадаад худалдаа 2016 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14.7%-иар буюу 102.7 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3%-ийг, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 3%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 10%-ийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 7 нэгж хувиар буурчээ.

**Хүснэгт 5.** Импортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>298</b>	<b>30%</b>	<b>230</b>	<b>33%</b>	<b>210</b>	<b>35%</b>	<b>(68)</b>	<b>-23%</b>	<b>-7%</b>	<b>(20)</b>	<b>-9%</b>	<b>-3%</b>		
Түргэн эдлэгээтэй	178	158	16%	152	133	19%	162	119	20%	(25)	-16%	-3%	(14)	-11%	-2%
Хүнс	78	108	11%	75	91	13%	79	82	14%	(17)	-16%	-2%	(9)	-10%	-1%
Эм, гүрлэ	1	17	2%	1	16	2%	0	15	2%	(1)	-8%	0%	(1)	-7%	0%
Бусад түргэн эдлэгээтэй бараа	99	33	3%	76	26	4%	82	22	4%	(7)	-21%	-1%	(4)	-16%	-1%
Удаан эдлэгээтэй	28	140	14%	47	98	14%	28	92	15%	(42)	-30%	-4%	(6)	-6%	-1%
Гутал, хувцас, цүнх	6	14	1%	11	11	2%	14	11	2%	(3)	-24%	0%	(0)	0%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тэвчилгэ	6	29	3%	25	25	4%	3	19	3%	(4)	-13%	0%	(5)	-22%	-1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	79	8%	0	51	7%	0	48	8%	(28)	-35%	-3%	(3)	-6%	0%
Бусад удаан эдлэгээтэй бараа	15	18	2%	11	11	2%	11	14	2%	(7)	-39%	-1%	2	20%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>		<b>348</b>	<b>35%</b>	<b>207</b>	<b>29%</b>	<b>187</b>	<b>31%</b>	<b>(142)</b>	<b>-41%</b>	<b>-14%</b>	<b>(20)</b>	<b>-10%</b>	<b>-3%</b>		
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	7	209	21%	4	123	17%	3	110	18%	(86)	-41%	-9%	(12)	-10%	-2%
Суудлаас бусад твэрийн хэрэгсэл, эд анги	0	48	5%	0	18	3%	0	19	3%	(29)	-61%	-3%	1	5%	0%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	7	161	16%	4	104	15%	3	91	15%	(56)	-35%	-6%	(13)	-13%	-2%
Барилгын материал	317	105	11%	138	58	8%	77	38	6%	(47)	-45%	-5%	(20)	-34%	-3%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	11	34	3%	8	26	4%	6	38	6%	(9)	-25%	-1%	12	48%	2%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>		<b>117</b>	<b>12%</b>	<b>106</b>	<b>15%</b>	<b>113</b>	<b>19%</b>	<b>(11)</b>	<b>-10%</b>	<b>-1%</b>	<b>7</b>	<b>7%</b>	<b>1%</b>		
Хүнсний орц	10	6	1%	20	7	1%	80	18	3%	1	20%	0%	11	149%	2%
Химийн бүтээгдэхүүн	22	17	2%	24	16	2%	20	14	2%	(1)	-3%	0%	(2)	-13%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	4	3	0%	4	3	0%	4	4	1%	(0)	-1%	0%	0	15%	0%
Цахилгаан эрчим хүч	0	25	3%	0	32	5%	0	32	5%	7	28%	1%	0	0%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	0	0%	1	1	0%	(0)	-12%	0%	1	x10	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	173	67	7%	184	47	7%	151	45	8%	(19)	-29%	-2%	(2)	-5%	0%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>		<b>210</b>	<b>23%</b>	<b>247</b>	<b>15%</b>	<b>187</b>	<b>15%</b>	<b>(75)</b>	<b>-32%</b>	<b>-8%</b>	<b>(69)</b>	<b>-44%</b>	<b>-10%</b>		
Дизель түнш	109	119	12%	124	77	11%	84	35	6%	(42)	-35%	-4%	(42)	-54%	-6%
АИ-92, АИ-95	70	78	8%	96	60	9%	78	36	6%	(18)	-23%	-2%	(24)	-40%	-3%
А-80 болон бусад	30	35	4%	27	20	3%	25	17	3%	(15)	-43%	-2%	(3)	-15%	0%
<b>Бусад</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>0%</b>	<b>16</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>0%</b>	<b>(1)</b>	<b>0%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>996</b>		<b>702</b>		<b>599</b>		<b>(294)</b>	<b>-29.5%</b>		<b>(103)</b>	<b>-15%</b>			

% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

**Хүснэгт 6.** Импортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>	<b>(24.0)</b>	<b>118%</b>	<b>3.7</b>	<b>-18%</b>	<b>(20.3)</b>	<b>-9%</b>
Түргэн эдлэгээтэй	(0.6)	4%	(13.7)	96%	(14.2)	-11%
Удаан эдлэгээтэй	(23.5)	384%	17.4	-284%	(6.1)	-6%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>(55.2)</b>	<b>278%</b>	<b>35.4</b>	<b>-178%</b>	<b>(19.8)</b>	<b>-10%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(30.6)	246%	18.2	-146%	(12.4)	-10%
Барилгын материал	(15.8)	80%	(3.9)	20%	(19.7)	-34%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(8.8)	-72%	21.1	172%	12.3	48%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>3.0</b>	<b>41%</b>	<b>4.3</b>	<b>59%</b>	<b>7.3</b>	<b>7%</b>
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>(26.2)</b>	<b>38%</b>	<b>(43.0)</b>	<b>62%</b>	<b>(69.3)</b>	<b>-44%</b>
Дизель түнш	(16.8)	40%	(25.4)	60%	(42.2)	-54%
АИ-92, АИ-95	(8.6)	36%	(15.6)	64%	(24.1)	-40%
А-80 болон бусад	(0.9)	30%	(2.1)	70%	(2.9)	-15%
<b>Бусад</b>	<b>0.5</b>	<b>-54%</b>	<b>(1.3)</b>	<b>154%</b>	<b>(0.9)</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>(102.0)</b>		<b>(1.0)</b>		<b>(103)</b>	<b>-15%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Дүрслэл 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



Тойм тооцооллоос үзэхэд 2016 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр импортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 102.7 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ буурснаар уг бүлгийн импорт 8.8%-иар буюу 20.3 сая ам.доллараар буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 9.6%-иар буюу 19.8 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ зэрэг буурснаар уг бүлгийн импорт 44.0%-иар буюу 69.3 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 3 сарын байдлаар тонн тутамд 441.5 ам.долларт хүрээд байна.